

МОНГОЛ УЛСЫН ИХ СУРГУУЛЬ
ШИНЖЛЭХ УХААНЫ СУРГУУЛЬ
“МОНГОЛ СУДЛАЛ”
Эрдэм шинжилгээний сэтгүүл

Боть XLVII (597)

DOI: 10.22353/ms20234721

ЮАНЬ УЛСЫН ДУУРЬЛИГИЙН ЗАРИМ МОНГОЛ ҮГЭЭР
ДУНДАД ҮЕИЙН МОНГОЛ ХЭЛНИЙ АВИАЗҮЙН
ОНЦЛОГИЙГ ИЛРҮҮЛЭХ НЬ

Ш.Эгшиг
Бай Тинтин

Хураангуй: Юань улс оршин тогтнож байсан XIII-XIV зууны үед монгол, хятад хоёр үндэстэн нэгэн төрийн захиргаанд байж, улс төр, эдийн засаг, шашин соёлын талаар өргөн харилцаатай байсан учир тэр үеийн дуурьлигийн зохиолд цөөн бус монгол үг тохиолддог юм. Юань улсын үеийн дуурьлигийн хятад зохиолд тааралдах монгол үгийг хятадаар авиалан тэмдэглэж байсан нь тухайн үеийн монгол үгийн дуудлагыг мэдэх боломжтой болгоно. Иймд XIII-XIV зууны үеийн монгол, хятад хэлний авианы тогтолцоог судалж, тухайн үед бичигдсэн түүхэн дурсгал бичиг “Монголын Нууц Товчоон”, “Хуа-и и-юй хятад-монгол толь бичиг”, “Жун юань инь юнь (中原音韵)”, судалгааны бүтээл “Монгол хэлний түүхэн хэлзүй”, “Хятад хэлний авиа зүй (汉语音韵)”, “Хятад хэлний түүхийн ноорог (汉语史稿)” зэрэг ном, бүтээлтэй жишин, дуурьлигийн зохиолын монгол үгийг хятадаар авиалсан байдлыг шинжилснээр дундад үеийн монгол хэлний авиазүйн байдлыг тодруулан гаргав.

Түлхүүр үг: Юань улсын дуурьлиг, Юанийн ший жүжиг, дундад үеийн монгол хэл, авиазүй, ойрх үеийн хятад хэл

1. Удиртгал:

Юань улсын дуурьлиг (元曲yuan qu) бол Юань улсын үед цэцэглэн хөгжсөн уран зохиолын нэг төрөл бөгөөд тухайн үед зарим хүн үүнийг “домоҮ (传奇chuan qi)” хэмээн нэрлэж байжээ. Тан улсын үед үүссэн “дуурьлиг” хэмээх нь олон төрлийн урлагийн үзүүлбэрийг (яруу үглэл, дуу, хөгжим, акробат, бүжиг зэрэг) нэг дор цогцлоосон нэгэн төрөл урлагийн ерөнхий ойлголт юм. Сүн, Алтан улсын дуурьлигийн онцлогоос ялгахын тулд “Юань улсын дуурьлиг (元曲yuan qu)”, “Юанийн за жюй (元杂剧yuan za ju)” хэмээгддэг, хөгжмийн найруулгын хувьд хойд зүгийн хөгжимд тулгуурлан зохиосон учир “Хойд за жюй (北杂剧bei za ju)” гэгдэх ч болсон, Юань улсын монгол, хятад үндэстэн олон зохиолчийн бичсэн дуурьлигийн зохиолыг нэгтгэн нийтэд нь ‘Юань улсын дуурьлиг’ (YR) гэж нэрлэдэг юм. “元曲 (yuan qu)” гэх хятадын уран зохиолын энэ төрлийг монгол хэлээр ‘Юань улсын дуулалт жүжиг’, ‘Юань драм’, ‘Юанийн за жюй’, ‘Юанийн жүжиг’, ‘Хойд за жюй’ гэх зэргээр олон янзаар нэрлэн орчуулж ирсэн байна. Бид Хятадын Үндэстний хэвлэлийн хорооноос хэвлэсэн “Хятад-монгол

толь”-д буй ‘Юань улсын дуурьлиг’ (巴特尔, 2005, 页 1691) гэдэг монгол нэрийг энд хэрэглэлээ.

Судалгааны зорилго

Бид энэхүү өгүүлэлд Юань улсын дуурьлиг дахь зарим монгол үг хэллэгийг сонгон авч, “Монголын Нууц Товчоон” болон “Хуа-и и-юй хятад-монгол толь бичиг”-тэй харьцуулан, дундад үеийн монгол хэл ба ойрх үеийн хятад хэлний авианы тогтолцоонд суурилан монгол үгийг хятадаар авиаглах онцлогийг тодорхойлох болно.

Судалгааны арга

Бидний энэхүү өгүүлэлд дуурьлигийн зохиолд тэмдэглэсэн зарим монгол үг хэллэгийг хятадаар тэмдэглэсэн онцлогийг тогтоохдоо дундад үеийн монгол хэл ба хятад хэлний түүхийн үечлэлээр 12-19-р зууныг хамрах ойрх үеийн хятад хэлний авианы онцлогт тулгуурлан, **харьцуулах, задлан шинжлэх, нэгтгэн дүгнэх** зэрэг аргыг хэрэглэлээ.

Судалгааны хэрэглэгдэхүүн

Энэхүү өгүүлэлд Фан Лингүй (方龄贵)- ийн монгол үг хэллэгийг эмхэтгэн туурвисан “Юань Мин улсын ший дуурьлиг дахь монгол хэл (元明戏曲中的蒙古语)” (方龄贵, 2014) бүтээлийг судалгааны эх хэрэглэгдэхүүн болголоо.

Тус өгүүлэлд бид түүхэн дурсгал бичиг болох “Монголын Нууц Товчоон”, “Хуа-и и-юй хятад-монгол толь бичиг”, “Жун юань инь юнь (中原音韵)”, судалгааны бүтээл “Монгол хэлний түүхэн хэлзүй”, “Хятад хэлний авиа зүй (汉语音韵)”, “Хятад хэлний түүхийн ноорог (汉语史稿)” зэрэг бүтээлийг ашиглан, Юань улсын дуурьлигийн зохиолд тааралдах зарим монгол үгийг хятадаар авиалах онцлогийг доор авч үзлээ. Ингэхдээ Орчин цагийн монгол хэл (ОЦМХ), Монголын Нууц Товчоон (MNT), Хуа-и и-юй хятад-монгол толь бичиг (HUA), Монгол хэлний түүхэн хэлзүй (MXTX), Юань Мин улсын ший дуурьлиг дахь монгол хэл буюу元明戏曲中的蒙古语 (YMXQM) бүтээлийг тус тус товчлон хэрэглэлээ.

Дундад ба ойрх үеийн монгол хятад хэл

Дундад үеийн монгол хэлний авиа, ойрх үеийн хятад хэлний авианы тогтолцоо, хоёр хэлний тохиролцоог сэдэвтэй холбогдуулан товчхон танилцуулья.

Д.Төмөртоогоо монгол хэлийг түүхэн үүднээс дараах байдлаар үечилсэн байдаг (Төмөртоогоо, 1992, хууд. 7). Тухайлбал:

1. Өвөг монгол хэл
2. Эртний монгол хэл
3. Дундад үеийн монгол хэл
4. Орчин цагийн монгол хэл

Эдгээрээс дундад үеийн монгол хэлэнд XI-XII зууны үеэс XV-XVI зуун хүртэлх үеийг хамааруулан үзээд дундад үеийн монгол хэлний онцлог нь:

а. Үгийн эхний **p** буюу **f** нь **h** буюу **x** болжээ.

б. **aYa**, **aYu** гэх мэт цогцууд доторхи **Y g** сугарчээ.

в. **i** нугарч, **e** уруулшиж эхэлсэн (Төмөртоогоо, 1992, хууд. 2) хэмээн тодорхойлжээ.

Хятад хэлний авиа зүйг түүхэн хөгжлийн үе шатаар үечлэн хуваахад, хятадын судлаачид ихэвчлэн доорх мэт хэдэн төрөлд ангилж үздэг. Жишээлбэл: Ван Ли (王力, 汉语音韵, 2003, 页 10):

1. Нэн эртний авианы дуудлага (НТӨ IV-аас өмнө)

2. Дундад эртний авианы дуудлага (НТӨ IV-XII зуун хүртэл)

3. Ойрх үеийн авианы дуудлага (НТ XII зуунаас хар тамхины дайн (1860 оны үе хүртэл)

Орчин цагийн авианы дуудлага (Хар тамхины дайны үеэс өнөөг хүртэл) (王力, 汉语音韵, 2003, 页 12) гэж хуваажээ. Д.Бүргэд:

1. Эртний үе нь НТӨ-оос XI-VII зуун хүртэлх цаг үе

2. Дундад эртний цаг үе нь VII-X зуун хүртэлх

3. Ойрх үе нь X-XX зууны эхэн үе хүртэлх

Орчин цагийн үе нь XX зууны эхнээс өдгөө хүртэлх цаг үе болно (Бүргэд, 2019, хууд. 53) хэмээн хуваан авч үзэж тайлбарласан байна.

Энэ үечлэлээс үзэхэд, Юань улсын дуурьлигт тааралдах монгол үг хэллэг нь барагцаалбал гуравдугаар шат буюу ойрх үеийн хятад галигийн авианы судлалд хамаарах юм. Ойрх үеийн хятад авианы онцлогийг төлөөлөх бүтээл бол 1324 онд Жөү Дөчин (周德清)-ийн найруулсан “Жун юань инь юнь (中原音韵)” хэмээх ном юм. Ван Ли (王力): “XIII зуунаас XVII зуунд (Юань, Мин улсын үе) зүүн хойд бүс нутгийн амьд хэлний судалгаа хийж байжээ. Энэ нь тухайн үеийн хятадын хэл шинжлэлийн гол хандлагыг харуулна. Үүнд, Жөү Дөчин (周德清)-ийн “Жун юань инь юнь” бол хойд дуурьлиг (北曲)-т зориулан найруулж, хятад авианы онцлогийг тусгасан бүтээл болно (王力, 汉语语音史, 2014, 页 342) хэмээн тайлбарлажээ. Ойрх үеийн хятад хэлний авианы онцлогийн тухай ойлголттой болоход төлөөлөх бүтээл болох энэ бүтээлийг эш баримт болгож үзэх нь зүйтэй болов уу. Үүнд:

1. Эгшиг авиа (韵母)

“Жун юань инь юнь” номд хятад үсгийн авиаг эгшиг авианд (韵母) нь үндэслэн 19 зүйлээр ангилан хуваажээ. Анги бүрийг хоёр хоёр үсгээр төлөөлөн нэрийдсэн байна. Үүнд: 东中(uŋ/iuŋ), 江阳(aŋ/iaŋ/uaŋ), 支思(ĭ), 齐微(i/ei/uei), 鱼模(u/iu), 皆来(ai/iai/uai), 真文(ən/iən/uən/iuən), 寒山(an/ian/uan), 桓欢(on), 先天(ien/iuen), 萧豪(au/iau/ieu), 歌戈(o/io/uo), 家麻 (a/ia/ua), 车遮(iε/iue), 更青(əŋ/iəŋ/uəŋ/iuəŋ), 尤侯(əu/iəu), 侵寻(əm/iəm), 监咸(am/iam), 廉纤(iem) нийт 46 эгшиг авиаг тэмдэглэсэн байна.

Ойрх үеийн хятад хэлний авианы онцлог нь орчин үеийн “e” эгшиг авиаг “iε”-ээр дуудаж, “m”-ээр төгсөх авиа оршиж, орчин үеийн Же мү (介母) болон эгшиг авиа нийлж нэг авиаг илэрхийлдэг байжээ.

2. Гийгүүлэгч авиа (声母)

Луо Чанпэй (罗常培) “Жун юань инь юнь” хэмээх номыг судлаад дундад зууны үед Зүүн Хойд бүс нутагт нийт 21 гийгүүлэгч авиа байгааг задлан тайлбарлажээ. Үүнд: p(崩), p'(烹), m(蒙), f(风), t(東), t'(通), n(农), l(龙), k

(工姜), k' (空腔), x (烘香), ts (宗), ts' (從), s (嵩), ʃ (支章), ʃ' (眇昌), ʃ (施商), ʒ (戎), v (亡), ɳ (仰), Ø (邕) (杨耐思, 2012, 页 105) байна. Үүнд, Ван Ли (王力)-ийн “Хятад хэлний түүхийн ноорог” (王力, 汉语史稿, 2004, 页 142–150) номд: Өнөөгийн бээжин аялгуунд байгаа j, q, x гийгүүлэгчийг хэлний хойгуурх (舌根音 she gen yin) k, k', x-ээр, хэлний урдуурх (舌尖音 she jian yin) ts, ts', s авиагаар дуудаж байжээ гэж тайлбарласан байна.

Юань улсын дуурьлигт тохиолдох зарим монгол үгийг хятадаар авиалсан байдал

Юань улсын дуурьлигийн зохиолд тааралдах монгол үгийг хятадаар бичихдээ голдуу нэгээс дөрвөн ханз үсгээр тэмдэглэсэн байдаг онцлогтой. Ханз үсэг бол дүрс-утгын бичиг бөгөөд дуудлага ижил, утга ондоо ханз үсэг олон байдаг. Ийм учраас Юань улсын дуурьлигт буй монгол үг хятад хэлэнд орохдоо ханз үсгийн өвөрмөц онцлогийн нөлөөгөөр нэг монгол үг олон бичлэгтэйгээр тэмдэглэгджээ.

1. Авианы сугарал

*Баатар 巴都儿 ba du er (YP) 把阿秃儿 (ba a tu er) (HUA) 把阿秃儿 (ba a tu er) (MNT)

Орчин үеийн монгол хэлний “баатар” гэдэг үг нь эртний монгол хэлэнд “baʁa:tur” (МХТХ) гэсэн хэлбэртэй байсан бол дундад үеийн монгол хэлэнд (Ү) авиа сугарч (把阿秃儿) (baʁa:tur) (МНТН) болжээ. Үүнд “把阿秃儿” буюу хятад хэлний онцгой авианы хэлбэр “兒, 儿, 二.....”, “er” гэх ханз үсгийн дуудлага нь нарийн будилаантай хөгжлийн цаг үеийг дамжин ирсэн байдаг билээ. “а” авиа нь Юань, Алтан улсын үеийн “л” авианы суурин дээр, Мин улсын эхэн үед үүсэн бүрэлдсэн байна. Мөн “er” авиа нь дуурьлигийн зохиол “Жинь пин мэй (金瓶梅)”-д олон удаа ижил дуудлагын үгс гарсан байна” (李思静, 1986, 页 42) гэж тайлбарлажээ. Үүнээс харахад “er” авиа тухайн үед нэгэнт бий болсон байжээ.

Юань улсын дуурьлигт (баатар) хэмээх үг нь: 把都儿 (ba du er), 巴都儿 (ba du er), 把都 (ba du) хэмээх гурван янзаар бичигдэж, дундад зууны үеийн монгол хэлний авианы онцлогт тулгуурлан ба’атур (baʁa:tur) хятад хэлэнд бичигдэхдээ дөрвөн үе буюу дөрвөн ханз үсгээр бүтэх бөгөөд Юань улсын дуурьлигт тохиолдох 巴阿秃儿 (ba a tu er) гэх (а) богино эгшгийг хадгалж дөрвөн ханз үсгээр бичсэн үзэгдэл байхгүй бөгөөд бүгд хоёр буюу гурван ханз үсгээр 巴图儿 (ba tu er) гэж, (а) богино эгшгийг галиглан тэмдэглээгүй байна. Үүний шалтгааныг “Хэрэв богино эгшиг үүсмэл урт эгшигтэйгээ ижил байвал авианы нөлөөтөх хувьсал (ижилшил Д.З) явагдахад тодорхой хугацаа шаардахгүй” (Заяабаатар, 2022, хууд. 95) хэмээн үзсэнтэй харьцуулбал, дундад үеийн бичгийн хэлэнд (baʁa:tur) гэж (Ү) авиа сугарч (а) авиа хадгалагдаж байсан ч, ярианы хэлний онцлогийг хадгалсан бүтээл болох дуурьлигт буюу тухайн хүмүүсийн өдөр тутмын хэрэглээний дунд 巴图儿 (ba tu er) гэхийн (а) богино эгшиг богино

хугацаанд арынхаа үүсмэл урт эгшигтэйгээ ижилшиж, орчин үеийн дуудлагатай адил уртаар дуудагдах болсон ажээ.

*Уул 沃刺 (ao la) (YMXQM) 阿兀刺 (a wu la) (HUA) 阿兀拉 (a wu la) (MNT)

Орчин цагийн монгол хэлний (уул) хэмээх үг нь эртний монгол хэлэнд (aYu:la) (MXTX) байсан бол дундад зууны үед (Y) авиа сугарч, (a>u:la) (MXTX) болжээ. Дундад үеийн монгол хэлний авианы онцлогт суурилан (a>u:la) хэмээх авианы хэлбэрийг хятадаар галиглахдаа гурван үе буюу гурван ханзаар бичигдэх нь зүйтэй юм. Юань улсын дуурьлигт ‘уул’ хэмээх үгийг 沃刺 (ao la), 阿郭拉 (a gu la), 阿兀刺 (a wu la), 阿兀刺 (a wu la), 沃兀刺 (ao wu la), 沃喇 (ao la) гэсэн зургаан янзаар авиалан галиглажээ. Дээрх хэдэн хувилбараас харахад эртний монгол хэлний онцлогоо хадгалан бичигдэх хэлбэр (aYu:la) 阿郭拉(a gu la) хэдий байгаа боловч олонх нь Y авиа сугарч (a>u:la)阿兀拉(a wu la) гэж дундад үеийн монгол хэлний авианы онцлогийг тусгасан байдлаар хэрэглэгдэж байсныг харуулж байна.

2. Авианы ижилшил

*Өдөр 兀堵儿 (e du e) (YMXQ): (兀都兒) (wu du er) (HUA) 兀都兒 (wu du er) (MNT)

Орчин цагийн монгол хэлний (өдөр) гэдэг үг нь эртний монгол хэлнээ (edür) (MXTX) гэж, дундад зууны үед хүчтэй эгшигтээ татагдан хэлэгдэх байдлаараа ижилшиж (üdür) (MXTX), 兀都兒 (wu du er) (HUA) (MNT) гэж бичигджээ. Энэ нь тэргүүн үеийн эгшиг хүчтэй эгшигтээ татагдан нэгэнт ижилшсэнийг нотолж байна.

3. Авианы сулрал

“X” авианы тэмдэглээ

Монгол хэлний “х” гийгүүлэгч авиа эртний үед хамжих “k” гийгүүлэгчээр дуудагдаж байсантай холбоотой олон судалгаа гарсан байдаг. Юань улсын дуурьлигт орсон монгол үг тухайн үед тэмдэглэх онцлогийг авч үзвэл,

*Хүн 古温 (gu wen) (YMXQM): 古温 (gu wen) (HUA) 古温 (gu wen) (MNT)

Орчин цагийн монгол хэлний “хүн” хэмээх үгийг дундад зууны үед 古温(gu wen) (HUA), 古温(gu wen)(MNT) гэж тэмдэглэсэн бол Юань улсын дуурьлигт 古温 (gu wen) 苦温 (ku wen) 苦文(ku wen) хэмээх гурван янзаар тэмдэглэжээ. Үүнээс үзэхэд ‘хүн’ гэдэг үгийн (q) авиаг Юань улсын дуурьлигт “古gu” буюу (Y) буюу “苦ku” буюу (k) авиагаар галигласан нь тухайн үеийн аман ярианы онцлогийг тусгасан бололтой.

4. Үгийн эцсийн бүс хос эгшиг

*Сайн 撒因 (sa yin) (YMXQM) 撒因(sayin) (HUA) 撒因 (sayi:n) (MNT)

Орчин цагийн монгол хэлний (сайн) хэмээх үгийн “Урт (i:) эгшгийн өмнө байсан шүргэх (y) нь адил байранд байсан дундад зууны үед (Y/g) гийгүүлэгчээсээ хойно сулран сугарсан байна. Тийм учраас дундад үеийн олонх бичгийн дурсгалуудад хэвээр хадгалагдан үлджээ” (Төмөртоогоо, 1992, хууд. 8). Бидний судалгаанд хамаарах Юань улсын дуурьлигт “сайн” хэмээх үгийг 撒因(sa yin), 赛银(sa yin), 赛艮(sai gen), 撒嬴(sa ying), 洒银(sa yin) гэх таван

янзаар галиглажээ. Үүнээс харахад дундад үеийн монгол ярианы хэлэнд (y) авиа хадгалан хэрэглэгдэж байсан аж.

5. Үгийн эцсийн хос эгшиг

Нохой 奴海 (nu hai) (YMXQM): 狗(那孩) (naqai)(HUA) (那^中孩) (na^{zhong} hai) (MNT)

Орчин цагийн монгол хэлний “нохой” хэмээх үг нь өвөг монгол хэлэнд (noqai), дундад зууны монгол хэлэнд (noqai) (MXTX) (HUA) гэж бичигдэж байжээ. Юань улсын дуурьлигт 奴海 (nu hai), 那海(na hai), 讷和(ne he), 奴害(nu hai), 那害(na hai), 奴孩(nu hai), 脑海(nao hai), 诺海(nuo hai) хэмээн галигласан байна. Энэ нь мөн үед үгийн эцсийн хос эгшиг нэгэнт үүсэн бүрэлдсэн байсныг нотлох баримт болно.

6. (中) (舌) буюу өгүүлэх арга ба хэлэгдэх байрыг заасан тэмдэглэгээ

*Морь 抹邻 (mo lin) (YMXQM) 馬(抹^舌鄰) (mo^{she} lin) (HUA) 馬(秣^舌驪) (mo^{she} li)(MNT)

Орчин цагийн монгол хэлний (морь) хэмээх үг дундад зууны үед “MNT”-д (抹^舌鄰) (mo^[she] lin) гэж, “HUA”-д (秣^舌驪) (mo^[she] li) гэжээ.

“MNT”-д ‘舌^{she} la’ гэдэг нийлмэл галиг нь монгол хэлний ‘ra’ авиаг илэрхийлнэ. ‘舌^{she}’ хэмээх жижиг үсэг нь эхний гийгүүлэгч ‘l’-ийг ‘r’ гийгүүлэгчээр дуудах заавар мөн гэж ойлгож болно.” (Бүргэд, 2019, хууд. 31).

Юань улсын дуурьлигт 抹邻 (mo lin), 母麟(mu lin), 牟麟(mou lin), 抹伦(mo lun), 抹邻(mo lin), 莫林(mo lin), 末里(mo li), 牧林(mu lin) хэмээх найман янзаар авиалан тэмдэглэж, (邻lin) үгийн зүүн дээд хэсэгт жижгээр тэмдэглэгээ тавиагүй боловч монгол хэлний “l” гийгүүлэгч авиаг “r” -ээр дуудах зааврыг баримталж байсан нь тодорхой байна.

*Хатан 哈敦(ha dun) (YP): 娘子(哈敦) (ha dun) (HUA) (中合敦)(^{zhong} he dun) (MNT)

Орчин цагийн монгол хэлний “хатан” хэмээх үгийг дундад үеийн толь бичигт 哈敦(ha dun) (HUA), (合^中秃) (MNT) гэж тэмдэглэжээ.

“MNT”-д “中合^{zhong} he” гэдэг нийлмэл галиг нь монгол хэлний ‘qa’ авиаг галиглан тэмдэглэхийн тулд хэрэглэгдсэн бөгөөд үүнийг эрдэмтэн Ян Найсы (杨耐思) 歌戈 ge ge(o, io, uo) эгшиглэлийн бүлэгт багтах бөгөөд (хо) гэж дуудлагыг нь сэргээн тогтоосон байдаг. Тэгвэл ‘中^{zhong}’ хэмээх жижиг үсэг нь их төлөв эхний гийгүүлэгч нь “х” ‘k’ k” гэх дан галигийг ‘q, ʏ’ болгон дуудах заавар юм” (Бүргэд 2019: 31. Тэгвэл, Юань улсын дуурьлигт 哈敦 (ha dun) 哈墩 (ha tun) 哈屯 (ha tun) хэмээх гурван бичлэгийн хэлбэрийн “中^{zhong}” хэмээх жижиг үсэг хадсангүй боловч “哈^{ha}” үсгээр тэмдэглэжээ. Энэ нь түүний илтгэх авианы далд хэлбэрийг хадгалж тэмдэглэгдсэн байна гэж үзлээ.

7. (克^{ke}), (惕^{ti}), (黑^{hei}) буюу дэвсгэр үсгийн тэмдэглэгээ

*Хишигтэн 怯薛(qie xue)(YMXQM): 客薛^克 (ke xue^{ke}) (HUA) 客薛^惕 坤 (ke xue^{ti} kun) (MNT)

Орчин цагийн монгол хэлний “хишигтэн” хэмээх үг Юань улсын дуурьлигт 怯薛台(qie xue tai), 怯薛歹(qie xue dai), 客失克(ke shi ke), 怯薛丹(qie xue dan) хэмээн бичигджээ. “MNT” -д монгол хэлний “ki” авиаг “乞^{qi}”, ‘hi’ авиаг “希^{xi},

喜xi, 蟾xi” (Бүргэд 2019, 60) тэмдэглэгдэжсэнтэй харьцуулахад, Юань улсын дуурьлигт монгол хэлний “q” авиаг хятад хэлэнд “怯q ” буюу “k”-ээр бичсэн нь тухайн үед монгол хэлний “q” авиаг “k”-ээр тэмдэглэгдэж байсныг давхар нотолж байгаа юм. “MNT”-д монгол хэлний “š” авиаг “西xi 昔xi” буюу “失shi 石shi 拭shi 食shi 實shi 濕shi 試shi 釋shi”(Бүргэд 2019, 60) тэмдэглэж, “薛xue” үгийн баруун доор талд жижиг үсэг бүхий галиг “^{克ke 惕ti}” нь монгол хэлний “-k, -t” дэвсгэр үсгийг галиглахдаа ашигласан жижиг үсэг болно (Бүргэд 2019, 31) хэмээн тайлбарлажээ. Монгол, хятад хэлний үеийн бүтцийн ялгаанаас үүдэн, монгол хэлний битүү үеийн “-C” дэвсгэр үсгийг жижгээр тэмдэглэх хэлбэр дуурьлигийн зохиолд заримдаа тохиолдож, зарим үед тохиолдохгүй байна.

*Ал- 哈喇(ha la) (YMXQM): 阿剌^黑 (a la^{hei}) (HUA) 阿剌^黑 (a la^{hei}) (MNT)

Монгол хэлний (алах) хэмээх үйл үгийн битүү үеэр төгссөн “q” авиаг “MNT” болон “HUA”-г тэмдэглэхдээ “^{黑hei}” хэмээх жижиг үсгээр тэмдэглэсэн байна. “MNT”-д монгол хэлний үеийн эцсийн дэвсгэр гийгүүлэгчийг тэмдэглэсэн жижиг үсэг “^{黑hei}” нь “-q” гэх дэвсгэрийг илтгэсэн байна” (Бүргэд 2019, 31) хэмээн тайлбарлажээ. Дуурьлигийн зохиолд 哈喇(ha la) гэж монгол хэлний “CVC” гэсэн битүү үеийн эцсийн дэвсгэрийг тэмдэглээгүй нь ажиглагдлаа.

8. Хятад хэлний “j, q, x” авиаг тэмдэглэх хэлбэр

*Охин 阿斤(a jin) (YMXQM): 幹勤 (wo qin) (HUA) 幹勤 (wo qin) (MNT)

Орчин цагийн монгол хэлний “охин” гэдэг үг түүхэн дурсгал бичигт 幹勤 (wo qin)(HUA)(MNT) гэж бичигджээ. “MNT”-д монгол хэлний “o” эгшиг авиаг галиглан тэмдэглэсэн 48 хятад үсэг байна. ‘Жун юань инь юнь’ (ZYYY) бичигт энэ 48 үсгийн 27 нь 歌戈 ge ge (o, io, uo), 5 нь 車遮 che zhe (ie/iue), 3 нь 蕭豪 xiao hao (au, iau, ieu), 1 нь 家麻 jia ma (a, ia, ua) ба 歌戈 ge ge (o, io, uo) эгшиглэлийн бүлэгт орсон байна”(Бүргэд 2019, 31). Юань улсын дуурьлигт “o” авиаг 家麻 jia ma (a, ia, ua) эгшиглэлийн бүлэгт хамаарагдах “a” эгшиг авиагаар тэмдэглэжээ. “MNT” -д монгол хэлний “gi” авиаг “吉ji, 汲ji”, “ki” авиаг “乞qi”, “hi” авиаг “希xi, 喜xi, 蟾xi”, (Бүргэд 2019, 60) (ханз үсгийн хойно орчин цагийн хятад хэлний галигийг хадав) галиглан тэмдэглэжээ. Дундад үеийн монгол хэлний “qi” авиаг “希xi, 喜xi, 蟾xi” ханз үсгээр тэмдэглэж, “希xi” авиа ойрх үед хятад хэлэнд “hi” -ээр дуудагдаж байсан гэсэн үг бөгөөд энэ нь монгол хэлний дуудлагатайгаа дүйцэж байгаа юм. Юань улсын дуурьлигт “охин 阿斤(a jin)” үгийн монгол хэлний “qi” авиаг хятад хэлэнд “ji” авиагаар тэмдэглэснээс үзвэл, энэ нь ойрх үеийн хятад хэлнээ “k” буюу “a kien” хэмээн дуудагдаж байсан гэж үзэж байна.

ОЦМХ	MNT	HUA	YP(YMXQM)
Баатар	把阿秃兒(ba a tu er)	把阿秃兒(ba a tu er)	把都儿(ba du er)
Уул	阿峯拉(a wu la)	阿兀刺(a wu la)	袄刺(ao la)
Өдөр	兀都兒(wu du er)	兀都兒(wu du er)	额都额(e du e)
Морь	馬秣 ^舌 驪(mo she li)	馬(抹 ^舌 鄰)(mo she lin)	抹邻(mo lin)
Хүн	古溫(gu wen)	古溫(gu wen)	古溫(gu wen)

Сайн	撒因(sayi:n)	撒因(sayin)	撒因(sa yin)
Хатан	中合敦(zhong he dun)	哈敦(ha dun)	哈敦(ha dun)
Нохой	那中孩(na zhong hai)	那孩(naqai)	奴海(nu hai)
Хишигтэн	客薛 _楊 坤(ke xue _{ti} kun)	客薛 _克 (ke xue _{ke})	怯薛(qie xue)
Алах	阿刺 _黑 (a la _{hei})	阿刺 _黑 (a la _{hei})	哈喇(ha la)
Охин	幹勤(wo qin)	幹勤(wo qin)	阿斤(a jin)

Хүснэгт 1. MNT, HUA, YMXQM дахь авианы тэмдэглэх хэлбэрийн харьцуулал

Тайлбар 1: Энэ хүснэгтийн YP(YMXQM) багананд “Юань Мин улсын ший дуурьлиг дахь монгол хэл” номын гарчиг хэсэгт тухайн үгийг тэмдэглэсэн бичлэгийн нэг хэлбэрээр бусад бичлэгийн олон хэлбэрийг төлөөлүүлэн оруулав.

Тайлбар 2: “MNT” болон “HUA”-д ханз үсгээр галигласан хэлбэрийг Вэбсайт: (言語資料検索, 2024) - ний дагуу шүүн оруулав.

Дүгнэлт

Юань улсын дуурьлиг нь хувь хүний туурвисан уран зохиолын бүтээл учраас монгол үгийг тэмдэглэх ханз үсгийн сонголт, авианы онцлогт тухайн зохиолчийн танин мэдэхүй, мэдлэгийн түвшин, үгийн сан зэрэг эл талын дотоод хүчин зүйлд нөлөөлөх нь тодорхой юм.

Юань улсын дуурьлигт буй зарим монгол үгийн авианы онцлогийг нэгтгэн дүгнэвэл,

1. Дундад үеийн монгол хэлний түүхэн дурсгал бичигт туссан авианы онцлогтой төсөөтэй байдлаар бичигджээ. Хоёр эгшгийн дундах “Y/g” авиа сулран сугарч, эгшгийг уртаар тэмдэглэх, (q) авиаг (g) буюу (k)-ээр тэмдэглэх, хүчтэй эгшигт татагдан авиа ижилших зэрэг үзэгдлийг тусгасан байна.

2. Үгийн эцсийн бус хос эгшиг “y” авиа хадгалагдаж, харин үгийн эцсийн хос эгшиг нэгэнт үүсэн бүрэлдсэн байжээ. Жишээлбэл: Сайн 撒因(sa yin), Нохой 奴海(nu hai)

3. Зарим үг дундад үеийн монгол хэлний дурсгалд тэмдэглэснээс илүү, орчин цагийн монгол хэлний дуудлагатай адилаар ярианы хэлэнд хэрэглэгдэж байсан нь ажиглагдаж байна. Жишээлбэл: Баатар (ba'a:tur)把突儿(ba tu er).

4. “Монголын Нууц Товчоон” болон “Хуа-и и-юй” толь бичигт тохиолдох монгол хэлний үгийг өгүүлэх арга ба хэлэгдэх байрыг заасан авианы тэмдэглэгээ (中) буюу (舌) дээд талд жижиг үсгээр тэмдэглэх хэлбэр Юань улсын дуурьлигийн монгол үгийн авианы тэмдэглээнд байхгүй боловч, түүний илтгэх авианы далд хэлбэр байна гэж үзлээ. Тухайлбал, “r” гийгүүлэгч авиаг “l”-ээр дуудах заавар, “中合” хэмээх “哈ha”-аар дуудах зааврыг баримтлан тэмдэглэсэн байна. Жишээлбэл, морь 抹邻(mo lin), 哈敦(ha dun), 哈茶儿(ha cha er) зэргийг дурдаж болно.

5. “Монголын Нууц Товчоон” болон “Хуа-и и-юй” толь бичигт монгол хэлний дэвсгэр үсгийг галиглахдаа баруун доор талд нь (克_{ke}), (楊_{ti}), (黑_{hei}) гэх жижиг үсгээр монгол хэлний “-k, -t, -q” дэвсгэр гийгүүлэгчийг тавьсан тэмдэглэгээ дуурьлигийн зохиолд заримдаа ижил тэмдэглэж, заримдаа тэмдэглээгүй өнгөрсөн байна.

6. Дундад үеийн монгол хэл ба ойрх үеийн хятад хэлний авианы онцлогт үндэслэвэл, Юань улсын дуурьлигт “охин” 阿斤(a jin)-ы орчин үеийн дуудлага “j” авиа ойрх үеийн хятад хэлэнд “k”

-ээр дуудагдаж, “охин” хэмээх үг тухайн үеийн хятад хэлэнд “a kien” хэмээн дуудагдаж байжээ . “Хишиг” 怯薛(qie xue)-ийн монгол хэлний “q” авиаг хятад хэлэнд “怯q ” буюу “k”-ээр бичигдэж, энэ нь тухайн үед монгол хэлний “q” авиаг “k”-ээр тэмдэглэж, монгол хэлний “s” авиаг “薛xue” буюу ойрх үеийн хэлний урдуурх “s” -ээр тэмдэглэж, “хишиг” хэмээх үгийг тухайн үед “k’ie siue” хэмээн дуудаж байжээ гэж хэлж болно.

7. Юань улсын дуурьлигийн зохиолыг бичсэн монгол болон хятад зохиолчид тухайн үед хятад хэлээр дуурьлигийн зохиол туурвихдаа Хуа-и и-юй толь бичиг шиг монгол үгийг хятад үсгээр хэрхэн бичих тухай авианы тогтсон жишиг хэрэглэсэн байж магадгүй. Үүнийг илтгэхүйц дуудлага ижил боловч, өөр өөр ханз үсгээр монгол үгийн үеийг авиалан тэмдэглэж байсан нь ажиглагдлаа.

Номзүй

- American Press Institute. (2010 оны 1 1). *Make Sentences Shorter*. <https://prsay.prsa.org/>: <https://prsay.prsa.org/2009/01/14/how-to-make-your-copy-more-readable-make-sentences-shorter/>-ээс гаргасан
- B.Jigmed. (2004). *Mongyol anayaqu uqayan-u teuke bolun surbulji bičig-ün sinjilege*. Kitad: Liyooning-un ündüsüten-ü keblel-ün qoriy-a.
- B.Jigmed. (2004). *Mongyol anayaqu uqayan-u teuke bolun surbulji bičig-ün sinjilege*. Kitad: Liyooning-un ündüsüten-ü keblel-ün qoriy-a.
- B.Jigmed. (2004). *Mongyol anayaqu uqayan-u teuke bolun surbulji bičig-ün sinjilege*. Kitad: Liyooning-un ündüsüten-ü keblel-ün qoriy-a.
- Brown, J. (2005). *I Feel Good: A Memoir of a Life of Soul*. New York: New AmericanLibrary.
- Buffon. (1999 оны 5 27). *Discours sur le style*. www.britanica.com: <https://www.britannica.com/topic/Discours-sur-le-style>-ээс Гаргасан
- Chisholm, B. C. (2019 оны 11 8). *THE RHETORIC OF AN EXCELLENT ESSAY*. www.isi.org: <https://isi.org/intercollegiate-review/the-rhetoric-of-an-excellent-essay/>-ээс гаргасан
- Dharma. (1986). *Altan kürdün mingyan kigesütü*. (Č. t. tayilburilaba, Хян.) Köke qota: Öbür mongyol-un arad-un keblel-ün qoriy-a.
- Grisham, J. (2017 оны 6 12). *Writing Advice from John Grisham*. publicationcoach.com.-ээс гаргасан
- Journal. (2022 оны 8 1). *162 Creative writing topics and ideas*. www.journalbuddies.com: <https://www.journalbuddies.com/creative-writing-2/creative-writing-ideas-2/>-ээс гаргасан
- Ledohowski, L. (2023). *How to Pick the Right Persuasive Essay Topic*. wizeprep.com.-ээс гаргасан
- Sfetcu, N. (2014). *Dance Music*. Nicolae Sfetcu.
- Shewan, D. (2023 оны 11 1). *16 Easy ways to improve your writing skills*. worldstream.com.-ээс гаргасан
- Б.Болдсайхан. (2003). “Буддын сургаал ба Шинжлэх ухаан”. Улаанбаатар.
- Б.Бямбадорж. (2014). *Монгол хэлний найруулга зүй*. Улаанбаатар: БитПресс.
- Бүргэд, Д. (2019). *Монголын нууц товчооны хятад галигт монгол хэлний авиаг тэмдэглэсэн зарчмын асуудал*. Улаанбаатар: Мөнхийн Үсэг ХХК.
- Бүтээл (博特乐图) . (2013). 当代草原艺术年谱 • 音乐卷. 呼和浩特: 内蒙古大学.
- Ван Хуйцин, С. Е. (2018). 乌兰牧骑精神. 北京: 方志出版社.
- Д.Батжаргал. (2015). *Илтгэх урлагийн онол, арга зүй*. Улаанбаатар: МУИС Пресс.
- Д.Отгонсүрэн. (1975). *Монгол хэлний найруулга зүй*. Улаанбаатар: Д.Сүхбаатарын нэрэмжит Хэвлэлийн комбинати.
- Д.Оюумаа. (2020 оны 1 2). *Бага ангийн сурагчдын зохион найруулан бичих чадварыг хөгжүүлэх арга зүй*. Боловсролын ерөнхий газар.-ээс гаргасан
- Д.Сэрдарам. (2014 оны 12 26). *Оюутан ба эсээ*. www.trends.mn: <https://www.trends.mn/n/539-ээсгаргасан>
- Д.Сэрдарам. (2014 оны 12 26). *Оюутан ба эсээ*. www.trends.mn: <https://www.trends.mn/n/539-ээсгаргасан>
- Д.Цэрэнсодном. (1997). *Монгол бурхан шашны уран зохиол*. Улаанбаатар: ШУА. ХЗХ.

- Д.Эрдэнэсан. (2021). *Монгол хэл заах арга*. Улаанбаатар хот: Соёмбо принтинг ХХК.
- Данжуур (Б. 66). (огноо байхгүй).
- Жавзанпагма. (2019). *Оюутны эсээ бичих чадварыг хөгжүүлэх нь*. Улаанбаатар.
- З.Айжан. (1997). *Л.Түдэвийн эссе, түүний онцлог, ур чадвар*. Улаанбаатар хот.
- Заяабаатар, Д. (2022). *Монгол хэл судлал Боть 1*. Улаанбаатар: Соёмбо принтинг.
- Лувсанжамц., н. (огноо байхгүй). *Увидасын үндэсний нэмсэн арга*. Бээжин: модон барын хэвлэл.
- Лувсанням., н. (огноо байхгүй). *Лхантав*. тод монгол үсгийн бичмэл судар.
- Мико (崔美子), Ч. (2015 оны 05 09). 当代蒙古族舞蹈音乐研究. 硕士论文, хууд. 33.
- Монтэнь, М. д. (2010). *Сонгомол эсээнүүд*. Улаанбаатар: Мөнхийн үсэг.
- Мэргэд гарахын орон. (1748). Бээжин.
- Номинзул. (2021 оны 12 2). *Би Америкийн их сургуульд яаж тэнцсэн бэ? Өргөдлөө хэрхэн бэлдсэн бэ?* www.youtube.com: <https://www.youtube.com/watch?v=5r6FagTUrvk>-ээс гаргасан
- Ө.Ганзориг. (2022 оны 5 3). *Бичих чадвар нь оюуны хамгийн дээд илрэл*. youtube.com: https://youtu.be/NQfOHuAxxgI?si=d_6hIpt9S7LIqO8D-ээс Гаргасан
- П.Батхуяг. (2018). *Эсрэг хурд буюу эсээний тухай эсээ*. Улаанбаатар: СэлэнгэПресс.
- Төмөртоогоо, Д. (1992). *Монгол хэлний түүхэн хэлзүй*. Улаанбаатар.
- Фэн, Ю. Б. (2018 оны 06 17). 关于问鼎“第十一届中国舞蹈‘荷花奖’民族民间舞评奖”群舞的解读. 当代舞蹈艺术研究.
- Ц. Өнөрбаян, Ж. (2007). *Эсээ бичихүйн үндэс*. Улаанбаатар: Бемби сан.
- Ц.Дэлгэрэхцэцэг. (2008). Япон хэлээр найруулан бичих чадвар дээшлүүлэх онол арга зүйн асуудал. *Докторын судалгааны ажил*.-Д Улаанбаатар: Монгол улсын их сургууль.
- Ц.Өнөрбаян, Ж. (2007). *Эсээ бичихүйн үндэс*. Улаанбаатар: Бемби сан.
- Ц.Сүхбаатар. (1993). *Найруулан бичих арга ухаан*. Улаанбаатар: ШУ-ы хэвлэлийн “Эрдэм” компани.
- Ц.Сүхбаатар. (2007). *Монгол хэлний найруулга зүй*. Улаанбаатар: 59.
- Ц.Сүхбаатар. (2007). *Монгол хэлний найруулга зүй*. Улаанбаатар: Удам Соёл хэвлэлийн газар.
- Цайлгана (柴拉干). (2015). 论蒙古族舞蹈道具的文化内涵及艺术表现力. 呼和浩特: 内蒙古大学艺术学院硕士学位论文.
- 巴特尔. (2005). 汉蒙词典. 北京: 民族出版社.
- 方岭贵. (2014). 元明戏曲中的蒙古语. 昆明: 云南人民出版社.
- 李思静. (1986). 汉语“儿”[ə]音史研究. 上海: 商务印书馆.
- 杨耐思. (2012). 近代汉语音论. 上海: 商务印书馆.
- 王力. (2003). 汉语音韵. 北京: 中华书局.
- 王力. (2004). 汉语史稿. 北京: 中华书局.
- 王力. (2014). 汉语语音史. 北京: 中华书局.
- 言語資料検索 . (2024 оны 04 11). K-Search (full-text) /漢字音訳資料: <http://hkuri.cneas.tohoku.ac.jp/project1/ftsdata/list?groupId=5>-ээс гаргасан

Товчилсон үгийн жагсаалт

ҮР	Юань улсын дуурьлиг
MNT	Монголын Нууц Товчоон
HUA	Хуа-и и-юй хятад- монгол толь
ОЦМХ	Орчин цагийн монгол хэл
ҮМХQM	元明戏曲中的蒙古语 Юань Мин улсын ший дуурьлиг дахь монгол хэл

Summary

During the 13th-14th centuries when the Yuan dynasty existed, the Mongolian and Chinese nationalities were under the same government and had extensive relations in terms of politics, economy, religion and culture, many Mongolian words occurred in the Yuan Plays of that time. Mongolian words encountered in the Yuan Plays' scripts of the Yuan Dynasty were phonetically recorded in Chinese, making it possible to know the pronunciation of Mongolian words at that time. Therefore, through the phonetic system of the Mongolian and Chinese languages of the XIII-XIV centuries we were comparing these mongolian words in historical sources like "Mongolian Secret History", "Hua-i i-yu Chinese-Mongolian dictionary", "Zhong yuan yin yun (中原音韵)", "Historical Linguistics of the Mongolian Language", "Phonology of the Chinese Language (汉语音韵)", "Sketches of the History of the Chinese Language (汉语史稿)", and after analysing them, the phonetics features are clarified.

Keywords: Yuan Plays, Yuan poetic drama, Medieval Mongolian, phonetics, Early Modern Chinese